БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 13 өдөр Дугаар А/223 Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.8, 15^1 дүгээр зүйлийн 15^1.1, 15^1.4, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дэх хэсэг, Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 5.5.2 дэх заалт 5.8, 8.2 дугаар зүйлийн 11.9, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2023 оны А/419 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих MNS 4946:2019 стандартын шаардлага хангасан спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл шинээр олгох (1) хуулийн этгээдийн нэрийн жагсаалтыг хавсралтаар баталж, зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар), Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн), Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах), хорооны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хууль, дүрэм журам, стандартыг зөрчсөн нь тогтоогдвол зөвшөөрлийг цуцалж хуулийн этгээдэд мэдэгдэхийг Ажлын хэсэг (Г.Дагвадорж)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

1226100636

AJIL\2026 он ажил\захирамж